



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,  
<http://www.mongolbank.mn>

2013. 08. 15 № A-1/1058

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр зээлийн  
2013 оны 2 дугаар улирлын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

Хувийг: Сангийн яаманд

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ


Н.ЗОЛЖАРГАЛ



143004

A5-2013.doc

Монголбанкны 2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдрийн 1/1058 тоот албан  
бичгийн хавсралт



## ТАНИЛЦУУЛГА

### *Банкны систем дэх Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)*

Төв банк болон банкуудын нэгдсэн дунгээр 2013 оны II улирлын эцэст Засгийн газрын нийт активын хэмжээ 1411.0 тэрбум төгрөг, нийт пассивын хэмжээ 3950.2 тэрбум төгрөг болж, ЗГЦЗ-ийн хэмжээ -2539.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь ЗГЦЗ өнгөрсөн улирлаас 477.8 тэрбум төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн үзүүлэлт байлаа (Хүснэгт 1).

*Хүснэгт 1. Банкны салбар дахь ЗГЦЗ (Монголбанкийг оруулсан дүн) (тэрбум □)*

Актив	III.31	VI.30	Өөрчлөлт	Пассив	III.31	VI.30	Өөрчлөлт
ЗГҮЦ	1 020,7	1 386,1	365,4	Төсвийн харилцах	2 678,4	2 452,6	(225,9)
Богино хугацаатай	523,3	573,0	49,6	Төгрөгийн	445,0	640,7	195,8
Дунд хугацаатай	497,3	813,1	315,8	Валютын	2 233,5	1811,8	(421,6)
ЗГ-т олгосон зээл	-	-	-	Төгрөгийн нөөц	356,2	371,5	15,2
Бусад	25,9	24,9	(1,0)	Нийгмийн даатгал	353,4	421,7	68,2
				ЗГ-ын санхүүжилт	529,1	562,8	33,6
				Бусад	146,2	141,7	(4,5)
<b>1. Нийт</b>	<b>1 046,6</b>	<b>1 411,0</b>	<b>364,5</b>	<b>2. Нийт</b>	<b>4 063,5</b>	<b>3 950,2</b>	<b>(113,3)</b>
				(1-2) ЗГЦЗ	(3 016,9)	(2 539,2)	477,8

Банкны систем дэх ЗГ-ын нийт активын хэмжээ мөн оны 1 дүгээр улирлаас 364.5 тэрбум төгрөгөөр буюу 34.8 хувиар өссөн бол ЗГ-ын нийт пассивын хэмжээ 113.3 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. ЗГ-ын активын өсөлтийг арилжааны банкуудын эзэмшиж буй ЗГҮЦ-ны 365.4 тэрбум төгрөгийн өсөлт тайлбарлаж байгаа бол пассивын бууралт нь Монголбанкин дахь валютын харилцах данс 421.6 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Банкны систем дэх ЗГ-ын активын 8.1 хувь нь Монголбанкинд, 91.9 хувь нь арилжааны банкуудад байршиж байгаа бол нийт пассивын 72.1 хувь нь Монголбанкинд, 27.9 хувь нь банкуудад байршиж байна.

### *Төв банкин дахь ЗГЦЗ*


Монголбанкин дахь ЗГ-ын активын хэмжээ өмнөх улирлаас 53.3 тэрбум төгрөгөөр буурсан нь 50.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ эргэн төлөгдсөнтэй холбоотой байна. Улсын төсвийн төгрөгийн харилцах 195.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч, валютын харилцах 421.6 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын пассивын хэмжээ 242.4 тэрбум төгрөгөөр буурах шалтгаан болжээ. Тайлант улирлын эцэст ЗГЦЗ-ийн хэмжээ 189.2 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар өсч, -2.7 их наяд төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)*

Актив	III.31	VI.30	Өөрчлөлт	Пассив	III.31	VI.30	Өөрчлөлт
ЗГҮЦ	163,0	113,0	-50,0	Төсвийн харилцах	2678,4	2452,6	-225,9
ЗГ-т олгосон зээл	-	-	-	Төгрөгийн	445,0	640,7	195,8
Бусад	5,1	1,8	-3,3	Валютын	2233,5	1811,8	-421,6
				Төсвийн нөөц	356,2	371,5	15,2
	168,1	114,8	-53,3	Бусад	57,1	25,4	-31,8
<i>Төв банкин дахь ЗГЦЗ</i>					<b>3091,8</b>	<b>2849,4</b>	<b>-242,4</b>
					<b>-2923,8</b>	<b>-2734,6</b>	<b>189,2</b>


Монголбанкин дахь ЗГ-ын нийт активын 98.4 хувь нь ЗГҮЦ, 1.6 хувь нь хуримтлуулж тооцсон хүүний авлага байгаа бол нийт пассивын 35.5 хувь нь улсын төсвийн төгрөгийн харилцах болон нөөцийн дансанд, 63.6 хувь нь валютын харилцахад, 0.9 хувь нь бусад төрлийн дансанд<sup>1</sup> байна (Зураг 1а, 1б).

Зураг 1а. Төв банкин дахь ЗГ-ын актив



■ ЗГҮЦ ■ ХТХАвлага


Зураг 1б. Төв банкин дахь ЗГ-ын пассив



▨ Төгрөгийн харилцах ▨ Төгрөгийн нээц  
■ Валютын харилцах ▨ Бусад

Монголбанкин дахь ЗГЦЗ-ийн 2011-2012 оны өөрчлөлтийг улсын төсвийн төгрөгийн харилцах дансны өөрчлөлт голлон тайлбарлаж байсан бол 2012 оны 12 дугаар сард Монгол улсын ЗГ 1.5 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах дээр арилжаалсан ЗГЦЗ огцом буурах шалтгаан болжээ. Харин Чингис бондын зарцуулалттай холбоотойгоор 2013 оны 5 дугаар сараас улсын төсвийн валютын харилцах буурч, ЗГЦЗ-ийн хэмжээ өссөн байна. (Зураг 2).

Зураг 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



<sup>1</sup> Бусад пассив – Монголбанкин дахь улсын төсвийн валютын төслийн данс, KFW-ын данс, хуримтлуулж тооцсон хүүний эглог.

## Арилжааны банкууд дахь ЗГЦЗ

Тайлант улиралд арилжааны банкууд дахь ЗГ-ын активын хэмжээ өмнөх улирлаас 417.7 тэрбум төгрөгөөр буюу 47.6 хувиар нэмэгдсэн бөгөөд пассивын хэмжээ 129.2 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар өсчээ. Ингэснээр ЗГЦЗ-ийн хэмжээ 2013 оны 1 дүгээр улирлаас 288.6 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өсч, 195.4 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Арилжааны банкууд дахь ЗГЦЗ (тэрбум □)

Актив	III.31	VI.30	Өөрчлөлт	Пассив	III.31	VI.30	Өөрчлөлт
ЗГЦЗ	857,7	1273,1	415,4	Нийгмийн даатгал	353,4	421,7	68,2
Бусад	20,9	23,1	2,3	ЗГ-ын санхүүжилт	529,1	562,8	33,6
	878,5	1296,2	417,7	Бусад	89,1	116,4	27,3
					971,7	1100,8	129,2
				Арилжааны банкууд дахь ЗГЦЗ	-93,2	195,4	288,6

Нийт активын хэмжээ ийнхүү өссөн нь банкууд дахь ЗГҮЦ-ны хэмжээ 415.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Засгийн газар 2012 оны 12 дугаар сараас эхлэн ЗГҮЦ-ны анхдагч захын арилжааг Монголбанкаар дамжуулан хийх болсон бөгөөд тайлант улирлын эцэст борлогдсон ЗГҮЦ-ны үлдэгдэл 900.0 тэрбум төгрөг байна.


Банкууд дахь ЗГ-ын активын 44.2 хувийг богино хугацаатай ЗГҮЦ<sup>2</sup>, 54.0 хувийг дунд болон урт хугацаатай ЗГҮЦ<sup>3</sup>, 1.8 хувийг бусад төрлийн актив<sup>4</sup> эзэлж байна. ЗГ-ын нийт пассивын 51.1 хувь нь ЗГ-ын санхүүжилт, 38.3 хувь нь нийгмийн даатгал, 10.6 хувь нь бусад төрлийн пассив<sup>5</sup> байна (Зураг 3а, 3б).

Зураг 3а. Банкууд дахь ЗГ-ын актив



- Богино хугацаатай ЗГҮЦ
- Дунд, урт хугацаатай ЗГҮЦ
- ▨ Бусад

Зураг 3б. Банкууд дахь ЗГ-ын пассив



- Нийгмийн даатгал
- ЗГ-ын санхүүжилт
- ▨ Бусад

Арилжааны банкууд дахь ЗГЦЗ-ийн хэмжээ 2011 оны 7 дугаар сараас 2012 оны 5 дугаар сар хүртэл тогтмол буурч байсан нь засгийн газрын санхүүжилтийн өсөлттэй холбоотой байсан бол 2012 оны 12 дугаар сараас эхлэн ЗГҮЦ-ыг Монголбанкаар дамжуулан арилжааны банкуудад арилжаалах болсноор ЗГҮЦ-ны хэмжээ өсч, банкны систем дэх ЗГЦЗ-ийн хэмжээ огцом нэмэгдэж байна. (Зураг 4)


<sup>2</sup> Богино хугацаатай ЗГҮЦ-н 1 жил хүртэл хугацаатай ЗГҮЦ.

<sup>3</sup> Дунд болон урт хугацаатай ЗГҮЦ-нд 1-ээс дээш жилийн хугацаатай ЗГҮЦ.

<sup>4</sup> Бусад актив – Банкууд дахь үрьдчилж толжсон ба хойшлогдсои татвар, хүримтлуулж тооцсон хүүний авлага

<sup>5</sup> Бусад пассив – Орлогын итилжүүлэг, улсын төсвийн тусгай данс, улсын төсвийн хадгаламж, орон нутгийн төсөв

Зураг 4. Арилжсааны банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



ЗГЦЗ-ийн тайланг банкуудаар болон системийн хэмжээгээр Хавсралт 1-д үзүүлэв.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдааар

/сая төгрөгөөр/

ДАНС	БАНКУУД	Арилжааны банкүүд	Улирлын өсөлт /хувь/	Монголбанк	Улирлын өсөлт /хувь/	БҮГД ДҮН	Улирлын өсөлт /хувь/
<b>1. Засгийн газрын өр төлбөр</b>	<b>1 296 241,5</b>	<b>47,6</b>	<b>114 795,0</b>	<b>(31,7)</b>	<b>1 411 036,5</b>	<b>34,8</b>	
Урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар	2 929,0	(14,8)	-	-	2 929,0	(14,8)	
ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас	572 957,1	9,5	-	-	572 957,1	9,5	
ЗГ-ын дунд хугацаатай үнэт цаас	700 143,8	109,4	113 000,0	(30,7)	813 143,8	63,5	
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	20 211,6	16,1	1 795,0	(64,5)	22 006,6	(2,1)	
Засгийн газрын зээл	-	-	-	-	-	-	
ЗГ-ын бусад төрлийн өглөг	-	-	-	-	-	-	
<b>2. Засгийн газрын хөрөнгө</b>	<b>1 100 825,7</b>	<b>13,3</b>	<b>2 849 390,3</b>	<b>(7,8)</b>	<b>3 950 216,1</b>	<b>(2,8)</b>	
<b>Улсын төсөв</b>	<b>1 090 348,4</b>	<b>13,8</b>	<b>2 849 390,3</b>	<b>(7,8)</b>	<b>3 939 738,7</b>	<b>(2,7)</b>	
Улсын төсвийн төгрөгийн харилцах	-	-	640 734,0	44,0	640 734,0	44,0	
Улсын төсвийн төгрөгийн хугацаатай хадгаламж	1 531,9	(17,7)	-	-	1 531,9	(17,7)	
Улсын төсвийн төгрөгийн хугацаагүй хадгаламж	27,3	(90,2)	-	-	27,3	(90,2)	
Улсын төсвийн төгрөгийн нөөц	-	-	371 457,9	4,3	371 457,9	4,3	
Улсын төсвийн валютын нөөц	-	-	-	-	-	-	
Улсын төсвийн валютын харилцах	-	-	1 811 846,0	(18,9)	1 811 846,0	(18,9)	
Улсын төсвийн валютын хугацаатай хадгаламж	506,7	(57,7)	-	-	506,7	(57,7)	
Улсын төсвийн валютын данс (төсөл)	-	-	12 849,4	(28,2)	12 849,4	(28,2)	
Орлогын шилжүүлэг (төгрөг)	18 962,5	15,2	-	-	18 962,5	15,2	
Орлогын шилжүүлэг (валют)	8 955,7	4,9	-	-	8 955,7	4,9	
Нийгмийн даатгал (төгрөг)	421 680,4	19,3	-	-	421 680,4	19,3	
Нийгмийн даатгал (валют)	-	-	-	-	-	-	
Тусгай данс (төгрөг)	49 336,3	74,5	-	-	49 336,3	74,5	
Тусгай данс (валют)	26 571,1	42,9	-	-	26 571,1	42,9	
Засгийн газрын санхүүжилт	562 776,3	6,4	-	-	562 776,3	6,4	
Засгийн газар авах авлага (KFW II)	-	-	6 409,3	2,6	6 409,3	2,6	
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	-	-	6 093,8	(81,5)	6 093,8	(81,5)	
Өр барагдуулах албатай хийх тооцоо	-	-	-	-	-	-	
<b>Орон нутгийн төсөв</b>	<b>10 477,3</b>	<b>(24,5)</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>10 477,3</b>	<b>(24,5)</b>	
Орон нутгийн тусгай данс (төгрөгийн)	9 974,1	(25,6)	-	-	9 974,1	(25,6)	
Орон нутгийн тусгай данс (валютын)	503,2	6,6	-	-	503,2	6,6	
<b>3. ЗГ-ын цэвэр зээл (1-2)</b>	<b>195 415,8</b>	<b>309,7</b>	<b>(2 734 595,3)</b>	<b>6,5</b>	<b>(2 539 179,6)</b>	<b>15,8</b>	

Эх үүсвэр: Монголбанк болон банкуудын тайлан тэнцэл